**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Онгон сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: СБА-2022/116/НА-СТА-ТШЗ**


Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
Утас: 70518396 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Даваа
Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Аудитор: П.Наранцэцэг
Утас: 70512127 Цахим хаяг: sukhbaatar@audit.gov.mn



Цахим хуудас: www.audit.mn

Баруун-Урт

2022 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт ........ 2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 9
3. Аудитын тайлан ........ 11
3.1 Ерөнхий зүйл ........ 11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 11
3.4 Материаллаг байдал ........ 12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 13
3.8 Аудитын гол асуудал ........ 14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 15
4. Аудитын илрүүлэлт ........ 15
4.1 Зөвлөмж ........ 15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 16

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1. Аудитын санал дүгнэлт

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.02.25 № 26

танай ____________-ны №____________-т

СҮХБААТАР АЙМГИЙН ОНГОН СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Х.ПҮРЭВДАВАА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Онгон сумын цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Онгон сумын цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.НАРАНТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **46,353,644.51** | **43,342,060.37** |
| **33** | **АВЛАГА** | 180,000.00 | 398,584.36 |
| **335** | **Бусад авлага** | 180,000.00 | 398,584.36 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 180,000.00 | 398,584.36 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 46,173,644.51 | 42,943,476.01 |
| **351** | **Түүхий эд материал** | 00.00 | 604,000.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 00.00 | 604,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 42,773,644.51 | 39,669,476.01 |
| 35420 | Аж ахуйн материал | 37,528,172.51 | 38,437,672.51 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 312,292.00 | 404,673.50 |
| 35460 | Хүнсний материал | 4,933,180.00 | 827,130.00 |
| 35600 | Мал амьтад | 3,400,000.00 | 2,670,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **283,607,530.06** | **273,247,810.10** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 283,607,530.06 | 273,247,810.10 |
| **392** | **Биет хөрөнгө** | 277,403,530.06 | 267,043,810.10 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -22,308,272.70 | -31,162,303.14 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 33,279,140.00 | 34,418,940.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -22,783,723.58 | -25,294,123.45 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 35,272,397.21 | 37,311,397.21 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -30,866,332.87 | -33,040,422.52 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **329,961,174.57** | **316,589,870.47** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **515,500.00** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 515,500.00 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 515,500.00 | 00.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 515,500.00 | 00.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 335,500.00 | 00.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 180,000.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **329,445,674.57** | **316,589,870.47** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 329,445,674.57 | 316,589,870.47 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 162,085,528.15 | 149,229,724.05 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -12,855,804.10 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **329,961,174.57** | **316,589,870.47** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **409,996,900.00** | **413,877,700.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **12,399,000.00** | **2,670,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 12,399,000.00 | 2,670,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 12,399,000.00 | 2,670,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 12,399,000.00 | 2,670,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **20,420,400.00** | **25,782,600.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 377,177,500.00 | 385,425,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 840,000.00 | 2,160,000.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 00.00 | 1,100,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 180,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 160,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 660,000.00 | 900,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 19,580,400.00 | 23,622,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 19,580,400.00 | 23,622,600.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **411,876,290.49** | **426,733,504.10** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **411,876,290.49** | **426,733,504.10** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 388,940,890.08 | 423,507,350.64 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 277,938,828.36 | 305,628,300.80 |
| 210101 | Үндсэн цалин | 196,637,336.33 | 236,576,285.45 |
| 210102 | Нэмэгдэл | 45,869,476.33 | 43,572,008.50 |
| 210104 | Урамшуулал | 18,411,096.00 | 25,480,006.85 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 17,020,919.70 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 36,102,341.23 | 37,483,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,253,289.79 | 25,977,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,976,268.77 | 2,876,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,377,554.78 | 2,301,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 590,539.69 | 575,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,904,688.20 | 5,752,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 16,740,232.00 | 19,761,319.88 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,562,105.00 | 1,616,604.88 |
| 210302 | Түлш, халаалт | 14,853,227.00 | 17,514,715.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 324,900.00 | 630,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,924,690.00 | 1,056,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 213,000.00 | 74,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 743,290.00 | 258,250.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 100,000.00 | 215,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 868,400.00 | 508,850.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 30,941,160.00 | 28,732,610.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,230,800.00 | 30,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 27,170,710.00 | 26,135,410.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 539,650.00 | 2,567,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 134,000.00 | 1,485,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 134,000.00 | 1,485,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 144,000.00 | 14,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 144,000.00 | 14,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 794,800.00 | 5,839,700.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 794,800.00 | 5,839,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 24,220,838.49 | 23,505,319.96 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,003,564.00 | 8,719,600.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,366,765.00 | 1,247,200.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 17,850,509.49 | 13,538,519.96 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 22,935,400.41 | 3,226,153.46 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 22,935,400.41 | 913,198.62 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 22,935,400.41 | 913,198.62 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 2,312,954.84 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 2,312,954.84 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-1,879,390.49** | **-12,855,804.10** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-1,879,390.49** | **-12,855,804.10** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **97,596,880.00** | **51,397,641.97** | **162,085,528.15** | **00.00** | 311,080,050.12 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **97,596,880.00** | **51,397,641.97** | **162,085,528.15** | **00.00** | 311,080,050.12 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **97,596,880.00** | **51,397,641.97** | **162,085,528.15** | **00.00** | 311,080,050.12 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -12,855,804.10 | 00.00 | -12,855,804.10 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **97,596,880.00** | **51,397,641.97** | **149,229,724.05** | **00.00** | 298,224,246.02 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **397,597,900.00** | **411,387,700.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **660,000.00** | **00.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 660,000.00 | 00.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 660,000.00 | 00.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 660,000.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **396,937,900.00** | **411,387,700.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 377,177,500.00 | 385,425,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 180,000.00 | 2,340,000.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 00.00 | 1,100,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 180,000.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 340,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 900,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 19,580,400.00 | 23,622,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 19,580,400.00 | 23,622,600.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **396,937,900.00** | **408,208,900.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **396,937,900.00** | **408,208,900.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **374,002,499.59** | **404,802,746.54** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 277,603,328.36 | 306,362,385.16 |
| 210101 | Үндсэн цалин | 196,301,836.33 | 237,310,369.81 |
| 210102 | Нэмэгдэл | 45,869,476.33 | 43,572,008.50 |
| 210104 | Урамшуулал | 18,411,096.00 | 25,480,006.85 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 17,020,919.70 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 35,583,890.23 | 37,483,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,734,838.79 | 25,977,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,976,268.77 | 2,876,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,377,554.78 | 2,301,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 590,539.69 | 575,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,904,688.20 | 5,752,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 16,632,896.00 | 19,853,701.38 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,568,105.00 | 1,616,604.88 |
| 210302 | Түлш, халаалт | 14,745,891.00 | 17,607,096.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 318,900.00 | 630,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,352,890.00 | 1,315,550.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 143,900.00 | 394,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 743,290.00 | 247,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 100,000.00 | 215,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 69,100.00 | 24,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,296,600.00 | 434,350.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 34,114,430.00 | 24,000,560.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,037,500.00 | 148,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 30,084,980.00 | 22,049,160.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 991,950.00 | 1,803,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,934,000.00 | 2,976,700.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 121,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,934,000.00 | 2,855,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 144,000.00 | 14,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 144,000.00 | 14,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 856,800.00 | 752,700.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 856,800.00 | 752,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3,780,265.00 | 12,043,250.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 11,323,250.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,780,265.00 | 720,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **22,935,400.41** | **3,406,153.46** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 180,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 00.00 | 180,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 22,935,400.41 | 913,198.62 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 22,935,400.41 | 913,198.62 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 2,312,954.84 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 2,312,954.84 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **660,000.00** | **3,178,800.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **660,000.00** | **3,178,800.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **660,000.00** | **3,178,800.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 660,000.00 | 3,178,800.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 660,000.00 | 3,178,800.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-660,000.00** | **-3,178,800.00** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 409,047,700.00 | 405,821,546.54 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 409,047,700.00 | 405,821,546.54 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 409,047,700.00 | 405,821,546.54 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 306,370,400.00 | 306,362,385.16 |
| 210101 | Үндсэн цалин | 243,264,700.00 | 237,310,369.81 |
| 210102 | Нэмэгдэл | 48,778,100.00 | 43,572,008.50 |
| 210104 | Урамшуулал | 14,327,600.00 | 25,480,006.85 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 37,483,900.00 | 37,483,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,977,900.00 | 25,977,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,876,500.00 | 2,876,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,301,300.00 | 2,301,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 575,300.00 | 575,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,752,900.00 | 5,752,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 20,622,600.00 | 19,853,701.38 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,903,100.00 | 1,616,604.88 |
| 210302 | Түлш, халаалт | 17,567,500.00 | 17,607,096.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,152,000.00 | 630,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,544,500.00 | 1,315,550.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 418,900.00 | 394,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 350,000.00 | 247,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 341,100.00 | 215,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 96,700.00 | 24,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 337,800.00 | 434,350.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 24,840,700.00 | 24,000,560.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 148,200.00 | 148,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 22,887,900.00 | 22,049,160.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,804,600.00 | 1,803,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,140,000.00 | 3,995,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,140,000.00 | 1,139,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 2,855,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 117,000.00 | 14,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 117,000.00 | 14,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 816,700.00 | 752,700.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 816,700.00 | 752,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 13111900.00 | 12043250.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,480,600.00 | 11,323,250.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,631,300.00 | 720,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 409,047,700.00 | 405,821,546.54 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 385,425,100.00 | 383,112,145.16 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 385,425,100.00 | 383,112,145.16 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 23,622,600.00 | 22,709,401.38 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 23,622,600.00 | 22,709,401.38 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 31.00 | 27.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 22.00 | 21.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 05.00 | 04.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 03.00 | 01.00 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 01.00 | 01.00 |
| **631** | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | 01.00 | 01.00 |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 01.00 | 01.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **31.00** | **27.00** |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 19.00 | 18.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 09.00 | 08.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | 03.00 | 01.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **2,340,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **2,340,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 2,160,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 2,160,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 160,000.00 |
| 210602 | Тавилга | | 2,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 0.00 | 180000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 180,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | 180,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 2340000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 2,340,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 1,100,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 340,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 900,000.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Онгон сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн данс, үндсэн хөрөнгийн зардалтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Наранцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Онгон сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар аймгийн Онгон сумын хүүхдийн цэцэрлэг нь "Эрүүл мэндийг эрхэмлэн, хүүхэд бүрийг тоглох явцдаа "Би чадна" гэсэн итгэлтэй болгон хөгжүүлэхэд оршино." гэсэн эрхэм зорилготой байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай"
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Онгон сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

**3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 396.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 5.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Сүхбаатар аймгийн Онгон сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13.4 сая төгрөгөөр буюу 4.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая.төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| **Авлага** | 0.2 | 0.4 | 0.2 |
| **Бараа материал** | 46.2 | 42.9 | -3.3 |
| **Үндсэн хөрөнгө** | 283.6 | 273.2 | -10.4 |
| **Нийт хөрөнгө** | **329.9** | **316.5** | **-13.4** |
| **Өр төлбөр** | 0.5 | 0 | -0.5 |
| **Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/** | 311.8 | 298.2 | -13.6 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **311.6** | **298.2** | **-13.4** |

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 273.2 сая төгрөг болж 10.4 сая төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардлаар буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 298.2 сая төгрөг болж 13.4 сая төгрөгөөр буурсан байна.

Сүхбаатар аймгийн Онгон сумын хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 3.9 сая төгрөгөөр буюу 0.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 14.9 сая төгрөгөөр буюу 3.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, хоол хүнс зэрэг зардлууд байна. Энэ нь ковид19 цар тахлын хүрээнд цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоосон, засгийн газрын 2021 оны 43 дүгээр тогтоолын дагуу төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлсэнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 435.6 сая төгрөгөөр, нийт зарлагыг 435.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 24.3 сая төгрөгөөр бууруулж 411.3 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2021 онд ковид19 гарсантай холбогдуулан улс орон даяар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин, цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоосонтой холбогдуулан хоолны зардлыг бууруулж, төсөвт тодотгол хийсэн нь нөлөөлсөн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 411.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 408.2 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулж, 3.2 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нийт зардлын 387.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 23.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 2.3 сая төгрөг төвлөрч, уг хөрөнгийг багаж, техник, хэрэгсэл, тавилга, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллын зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Тайлант онд Сүхбаатар аймгийн Онгон сумын Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээнд зарцуулсан төсвийн гүйцэтгэл 99.2 хувийн биелэлттэй байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Онгон сумын хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотой санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 119 мэдээллээс хугацаандаа оруулсан 69 мэдээлэл, хугацаа хоцроосон 48 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолоор төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан байна. Тухайлбал:

- Тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”
- Тогтоолын 1.8-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах; гэж заасан байна”

Сангийн яамнаас 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Тодруулга хүргүүлэх тухай” Н-3/845 дугаар албан бичгийг Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна. Тус албан бичигт “Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д заасан “үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатай зардал, төсөл, арга хэмжээ” гэдэгт төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ажилтан, албан хаагчдад төлж байгаа цалин хөлс, олговор, ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, цахилгаан, халаалт, цэвэр, бохир ус, түрээсийн зардал болон байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой шаардлагатай бусад зардал хамаарна.” гэж тодруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4.9 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн актыг биелүүлсэн байна.

*Хүснэгт 2* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн актын бүрэн хэрэгжсэн.

/сая.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 1 | 4.9 | 1 | 4.9 | - | - | - |
| Нийт дүн | 1 | 4.9 | 1 | 4.9 | - | - | - |

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн Онгон сумын хүүхдийн цэцэрлэгийн тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудалгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитын явцад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал толилуулаагүй болно.

### 4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал***

*<u>1.1. Илрүүлэлт:</u>*

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 62 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцоолоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана" заалттай нийцэхгүй байна.

*<u>1.2. Өгсөн зөвлөмж:</u>*

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

***2. Шилэн данстай холбоотой асуудал***

3.1 *<u>Илрүүлэлт</u>:*

Шилэн дансны нэгдсэн сайтад тайлант хугацаанд оруулах мэдээллээс 48 мэдээллийг хуульд заасан хугацаанаас хоцроож мэдээлсэн байна.

3.2 *<u>Өгсөн зөвлөмж:</u>*

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг иж бүрэн, үнэн зөв байршуулж, олон нийтийг мэдээллээр хангах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Сүхбаатар аймгийн Онгон сумын хүүхдийн цэцэрлэг | 2 | - | - | - | - | - | - | - | 2 | - |